



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/325

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын сувилагч нарын нийгэмлэгээс 4 жил тутамд зохион байгуулан явуулдаг 4 төрөлт спортын арга хэмжээний төвийн бүсийн тэмцээн 2017 оны 09 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд Орхон аймагт зохиогдох гэж байгаатай холбогдуулан санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 4000000 /Дөрвөн сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Улсын чанартай спорт, соёл урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй төрлөөр орон нутагтаа зохион байгуулах зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ